

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Д. Хүрэлтогоо

**ХЯТАД-ЯПОНЫ СҮҮЛИЙН ҮЕИЙН
ХАРИЛЦААНЫ БАЙДАЛ**

Улс орнууд, түүний дотор нийгмийн өөр өөр байгуулалттай улсууд орчин үеийн олон улсын харилцаанд тууштай хэрэгжиж, нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хэвийн харилцаа тогтоож, найрсаг хамтын ажиллагаагаа хөгжүүлэн бэхжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргах нь зүйн хэрэг юм. Гэтэл Бээжингийн эрх баригчид бусад улсуудтай, түүний дотор Япон улстай төрийн харилцаагаа хэвийн болгохын төлөө хийж ирсэн оролдлого, одоо Японы талаар Тэдний явуулж байгаа бодлого нь алс хэтийн өөр зорилготой байгаа нь сүүлийн үеийн байдлаас улам тодорхой болж байна.

Азийн энх тайван, аюулгүй байдал энэ тивийн хоёр том гүрэн Хятад Японы харилцаа ямар зарчмын үндсэн дээр хэрхэн өргөжин хөгжихөөс багагүй шалтгаална. Иймд тус хоёр орны сүүлийн үеийн харилцааны байдлыг товч авч үзье.

Улс төрийн харилцаа. Хятад Японы хооронд дипломат харилцаа тогтоод зургаан жил болж байна. 1972 оны 9-р сард Хятад-Японы хооронд албан ёсны хэвийн харилцаа тогтсон нь тус хоёр орны хэлхээ холбооны хөгжлийн зүй ёсны үр дүн мөн бөгөөд Ази тивийн хүчний харьцаанд гарсан өөрчлөлтийн үр дагавар юм. Япон улс Хятадын гадаад бодлогод ямагт чухал байр эзэлсээр иржээ. БНХАУ Японтой төрийн харилцаагаа хэвийн болгохыг гадаад бодлогынхоо чухал зорилт болгон дэвшүүлсний нэгэн гол зорилго гэвэл Бээжингийн удирдлагад Японтой тогтоосон хэлхээ холбоогоо энх тайван, социализм, юуны өмнө түүний өмөг түшиг ЗХУ-ын эсрэг дайсагнасан үйл ажиллагаандаа ашиглах гэсэнд оршиж байна. Нөгөө талаар Хятад Японы харилцааны ахиц нь Хятад-Америкийн ойртолтод нөлөөлөх учиртай гэж Бээжин тооцоолсон юм. Бээжин-Токиогийн харилцааг хууль зүйн үндэстэй болгохын тулд Хятадын эрх баригчид Хятад, Японы хооронд «Энх тайван, найрамдлын тухай гэрээ» байгуулах асуудалд гол анхаарлаа тавьж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд сүүлийн жилүүдэд янз бүрийн оролдлого хийж ирлээ.

1972 оны 9-р сарын 29-нд Чжоу Энх-лай, К. Танака нарын гарын үсэг зурсан Хятад-Японы хамтарсан мэдэгдэлд зааснаар тус хоёр улсын засгийн газар нь дээр дурдсан гэрээ байгуулах хэлэлцээ хийх тухай харилцан тохиролцсон юм.

Хятадын Гадаад явдлын яамны орлогч сайд Хань Нянь-лун 1974 оны 11-р сард Токиод очиж гэрээ байгуулах асуудлаар Чжоу Энх-лайгаас Японы ерөнхий сайд, К.Танакад өгсөн илгээлтийг гардуулжээ. Хань Нянь-лунг Токиод байх хугацаанд «энх тайван, найрамдлын тухай гэрээ» байгуулах урьдчилсан хэлэлцээ эхэлж, гэрээг аль болох түргэн байгуулах зорилгоор хэлэлцээний явцад Хятадын тал нилээд асуудал дээр, түүний дотор Сенкаку арлууд болон Тайваны асуудлын талаар буулт хийж, дээрх асуудлуудыг хэлэлцэх явдлыг тодорхой бус хугацаагаар хойшлуулах санал тавьсан байна. 1975 оны 1-р сарын 16-нд хэлэлцээний II шат

эхэлж, 1915 онд багтаж гэрээнд гарын үсэг зурах төлөвтэй байгаа тухай Хятад, Япон хоёр тал нэг бус удаа мэдэгдэж байжээ. Гэвч «гуравдахь орнууд Азид жанжлахын эсрэг тэмцэнэ» гэсэн заалтыг гэрээнд оруулах асуудал дээр Бээжин Токио хоёр санал зөрсний улмаас уг хэлэлцээ төдөлгүй мухардалд оржээ, «Жанжлалын эсрэг тэмцэх» гэсэн зүйл хоёр орны харилцааны хүрээнээс хальсан тул түүнээс үүсэн гарах үр дагаврын хариуцлагаас зайлсхийх зорилгоор Японы засгийн газар нь уг зүйлд дөрвөн тайлбар өгсөн юм.¹

«Жанжлалын эсрэг тэмцэх» гэсэн хэллэгийг Бээжингийнхэн анх 1971 оны 1-р сарын 23-ны «Жэньминь жибао» сонины редакцийн өгүүлэлд хэрэглэсэн байна. Тэр үед «Зөвлөлт, Америк хоёр хэт их гүрний эсрэг» гэсэн утгаар уг лоозонг хэрэглэж байсан бол 1972 оны хоёрдугаар сард АНУ-ын ерөнхийлөгч Р. Никсон Хятадад айлчилснаас хойш «гурав дахь орнууд Азид жанжлал тогтоохын эсрэг тэмцэх» гэж хятадын эрх баригчид хэлдэг болсон төдийгүй, Хятад-Америкийн хэлэлцээний дүнд нийтэлсэн «Шанхайн албан мэдээнд» ч тийм заалт оруулсан юм. Түүнээс хойш «Жанжлалын эсрэг тэмцэх» гэдэг нь шууд Зөвлөлтийн эсрэг агуулгатай болжээ. Үүнийгээ Бээжингийн эрх баригчид огт нуухгүй байна. Жишээ нь БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Дэн Сяо-пин 1975 оны 4-р сарын 16-нд Японы бүддийн шашинтны байгууллага «Сака таккай»-н төлөөлөгч Д.Икэдатай ярилцахдаа «Хятад-Японы энх тайван, найрамдлын гэрээнд «Азид ноёрхлоо тогтоохыг эрмэлзэж байгаа гурав дахь орны эсрэг тэмцэнэ» гэдэг зүйл оруулах саналтай байгаа нь ЗХУ ын эсрэг тэмцэнэ гэсэн үг юм» гэж шууд мэдэгджээ.²

Бээжингийнхний ийм байр суурь нь «жанжлалын эсрэг тэмцэх» гэсэн Лоозонгоос болж Япон-Америкийн Ази дахь зөрчлийг хурцатгах явдлыг арилгасан боловч Япон-Зөвлөлтийн харилцаанд муугаар нөлөөлөх тул Токиогийн эрх баригчид «жанжлалын эсрэг тэмцэх» гэгч асуудалд энэхэн үедээ нилээд болгоомжтой хандаж байжээ.

Гэтэл Японы засгийн газар дээрх байр сууринаасаа няцаж, Хятад Японы хэлэлцээг мухардлаас огцом гаргаж, 1978 оны 7-р сарын 21-нд хэлэлцээг сэргээж 8-р сарын 12-ны өдөр Бээжинд Хятад-Японы «энх тайван, найрамдлын тухай гэрээ» гэгчийг байгуулж түүнд БНХАУ-ын Гадаад Явдлын яамны сайд Хуан Хуа, Япон улсын Гадаад Явдлын Яамны сайд С. Сонода нар гарын үсэг зуржээ.

Энэ гэрээг хоёр орны төрийн эрх барих дээд байгууллагуудаас баталсаны үндсэн дээр энэ оны 10-р сарын 23-нд батламж бичгийг нь Токиод солилцсоноор уг гэрээ хүчин төгөлдөр боллоо.

Японы засгийн газар Хятадын талын тулгасан «жанжлалын эсрэг тэмцэх» гэсэн зүйлд болгоомжилсон дүр үзүүлж байсан нь тактикийн асуудал байсан болохоос биш тууштай байр суурь биш байжээ. Учир нь 1972 оны 9-р сарын 29-нд нийтэлсэн Хятад-Японы хамтарсан мэдэгдлийн 7-р

1 Кинти Миядзава нь Микийн засгийн газрын эхний үед гадаад явдлын яамны сайд (1974—1976 оны 9-р сар) байв. Тэрээр 1975 оны 9-р сард «жанжлалын эсрэг тэмцэх» гэсэн заалтыг дор дурдсан дөрвөн тайлбартайгаар гэрээнд оруулах саналыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Уг зүйл нь аль нэгэн гуравдахь орны эсрэг чиглэхгүй.
 2. Уг зүйлийг хэрэгжүүлэх гэж Хятадтай хамтран ажиллахгүй.
 3. Уг зүйл нь зөвхөн Ази ба Номхон далайн районыг хамрах ёсгүй.
 4. Уг зүйл НҮБ-ын дүрэмд зохьцсон байх ёстой. «Иомиури симбун» 1976 оны 12-р сарын 2.
- 2 «Правда» сонин. 1975 оны 9-р сарын 10.

зүйлд «...хоёр улсын аль нэг тал нь Ази ба Номхон далайн районд жанжлахыг оролдох ёсгүй. Тал бүр нь ямарваа өөр улс буюу бүлэг улсуудын жанжлал тогтоох гэсэн чармайлтыг эсэргүүцнэ» гэж заажээ. Хятад-Японы гэрээний хоёрдугаар зүйлд «Гэрээ байгуулагч хоёр этгээдийн аль нэг тал нь Ази ба Номхон далайн районд буюу ямарваа бусад районд жанжлалыг санаархахгүй, мөн ямарваа бусад улс буюу бүлэг улсуудын жанлал тогтоох гэсэн чармайлтыг эсэргүүцнэ» гэж заасан байна. Мэдэгдэл ба гэрээний дээрхи хоёр зүйл бол утга агуулгын хувьд үндсэндээ адил юм. Харин гэрээнд «Ямарваа бусад районд» гэсэн үг орсноороо ялгаатай юм. Энэ бол Японы талын саналыг Хятадын тал харгалзан үзэж оруулсан хэрэг бөгөөд «жанжлалын эсрэг тэмцэнэ» гэсэн заалтын мөн зорилгыг ялимгүй булзааруулах гэсэн оролдлого юм. Үүнээс үзэхэд Хятадын эрх баригчдын тулгаж байсан зүйлийг Японы эрх баригчид анхнаасаа зарчмын хувьд зөвшөөрч байсан нь тодорхой байна. Дээрхтэй холбогдуулан хэлэхэд хэрэв Маогийн их гүрний дээрэнгүй үзэлтнүүд, империалист харгис хүчнийг эс тооцвол Азид болон ямарваа бусад районд» жанжлалаа тогтоох гэсэн тийм улс гүрэн байхгүй гэж баттай хэлж болно.

Сүүлийн жилүүдэд Хятадын эрх баригчид Зөвлөлтийн эсрэг үзлийг хөрөнгөтөн орнууд, түүний дотор Япон улстай харилцах харилцааныхаа үндэс болгож иржээ. Чжоу Энь-лай Японы эрх баригч либерал-ардчилсан намын нөлөө бүхий зүтгэлтэн С. Хоритэй ярилцахдаа «Япон, Хятад, хоёр улсын хооронд найрсаг харилцаа тогтох нь Японы талаар ЗХУ-ын баримталж байгаа байр суурийг өөрчлөхөд хүрэх юм»³ гэж мэдэгдсэн байна. Чжоу Энь-лайн энэхүү дүгнэлт гэрээ байгуулахын хойшлуулшгүй чухлыг Японы эрх ашигтай холбож түүнийг тэтгэн халамжлагчийн байр сууринаас хандаж байгаа мэт дүр үзүүлж буй боловч хэрэг дээрээ Япон, Зөвлөлт хоёрыг бие бейнх нь эсрэг турхирах замаар харилцааг нь хурцатгахад чиглэсэн хятадын ичнээ бодлогын илрэл байлаа. Ийнхүү Японыг Зөвлөлтийн эсрэг хандуулж талдаа татах гэсэн Бээжингийн бодлого нь Зөвлөлт-Японы сайн хөршийн харилцаа, найрсаг хамтын ажиллагааны цаашдын бэхжилтэд дайснагласан ашиг хонжооч адал балмад чиг шугам учир алсдаа уршигтай бөгөөд Япон, Хятадын ард түмний аль алины нь эрх ашигт харш хандлага болох нь эртнээс тодорхой байлаа. Тийм ч учраас Бээжингийн эрх баригчид, «энх тайван, найрамдлын тухай гэрээ» байгуулах асуудлаар хөөцөлдөхдөө юуны өмнө Японы харгис хүчин, түүний дотор хэт үндсэрхэг үзэлтнүүд, хонзогногчидтой сүлбэлдэж, тэдний дуу хоолойг Японы олон нийтийн санаа бодол болгон ашиглаж байжээ.

Японы засгийн газар ч гэсэн өөрийн талаас Бээжингийн их гүрний дээрэнгүй бодлогыг илэрхий дэмжээгүй дүр үзүүлж Хятадтай байгуулах гэрээг Зөвлөлтийн эсрэг «чиглэхгүй гэж удаа дараа мэдэгдэж байв. Гэвч «жанжлалын эсрэг» (эсвэл «жанжлал») гэдэг чухам үг нь харьцангуй шинэ үг боловч 1970-аад оноос буюу магадгүй түүнээс ч өмнө бээжингийнхний гадаад бодлогын тулгын чулуу болсон бөгөөд улмаар 1975 оны 1-р сард Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлаар баталсан Хятадын шинэ үндсэн хуульд тусгагдсаныг гадаадын хэвлэлийн мэдээ нотолсоор байна. «Жанжлалын эсрэг» гэдэг нь өнгөн дээрээ АНУ ба ЗХУ-аас өөрсдийн бодлогыг дэлхийн бусад улс орнуудад «албадан хүлээлгэх оролдлогыг» эсэргүүцэх нэртэй боловч уг бодлогын гол бай нь анхнаасаа ЗХУ болсон тухай бүр Микийн засгийн газрын үед буюу 1976

онд өрнөдийн хэвлэлд бичиж байлаа.⁴ Гэтэл Токиогийн эрх баригчид «Жанжлалын эсрэг» гэдэг заалт бол «Зөвлөлтийн эсрэг чиглэсэн зүйл биш» гэж гэрээнд гарын үсэг зурсанаасаа хойш ч нотлохыг оролдож байхад «Жэньминь жибао» сонин гэргүүн өгүүлэлдээ «жанжлалын эсрэг тэмцэх» тухай заалт бол уг гэрээний «чухал агуулга» гэж тэмдэглээд ЗХУ-ыг элдвээр дайран зүхсэн байна.⁵

Хятад-Японы гэрээ хоёр этгээдийн гэрээний хувьд хоёр орны хооронд өнө удаан энх тайван, найрамдалт харилцааг хөгжүүлэх тухай заасан нэгдүгээр зүйл нь уг баримт бичгийн гол агуулга байх ёстой юм.

Гэтэл Бээжингийнхэн «жанжлалыг хамтран эсэргүүцэх» тухай заасан гэрээний хоёрдугаар зүйлийг гол зүйл гэж үзэж байгаа бөгөөд тэр зүйл нь ЗХУ-ын эсрэг хандсаныг бусад хэлбэрээр шууд зарлаж байгаагаас үзэхэд уг гэрээ түрэмгий холбооны чанартай юм. Японы албаны хүмүүсийн хийсэн мэдэгдлээс үзвэл Хятадын эрх баригчид гурав дахь орнуудын «жанжлалын эсрэг» хийх тэмцэлд зэвсэг хэрэглэх явдлыг оролцуулж байгаа ажээ.⁶ Иймд Маогийнхан «жанжлалын эсрэг» тэмцэх нэрийдлээр аль нэгэн улсын эсрэг зэвсэг хангинуулах эрмэлзлэлээ гэрээ эрхийн баталгаатай болгож буй нь тодорхой байна. Тэгэхдээ империалист гүрний эсрэг биш, харин тэдэнтэй сүлбэлдэж юуны өмнө ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орнуудын эсрэг зэвсэгт түрэмгийллийг оролцуулан хүч хэрэглэхээс няцахгүй нь ойлгомжтой боллоо.

Олон улсын гэрээ хэлэлцээрийг үнэлэхдээ юуны өмнө түүнд оролцогч улсуудын ямар чиг зорилготой гадаад улс төрийн бодлого явуулж байгааг цэгнэж үзэх хэрэгтэй. Хятадын эрх баригчид их гүрний жанжлах бодлого явуулж байгаа төдийгүй түүнийгээ улам идэвхжүүлж, бусад орон юуны өмнө айл зэргэлдээ улсуудын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдалд заналхийлж, улмаар булаан эзлэх түрэмгий үйл ажиллагаагаа өргөжүүлэн цэрэг дайны бэлтгэлийг илтэд эрчимтэй явуулж, «Дэлхийн дайн зайлшгүй» гэж улангасан сурталчилж байна. Учир иймд Хятад-Японы гэрээ нь зөвхөн Зөвлөлтийн эсрэг чиглэсэн төдийгүй, социалист бусад орнууд түүний дотор БНМАУ-ын эсрэг чиглэсэн цэргийн холбооны шинж чанартай юм. БНМАУ-ын талаар Хятадын эрх баригчид түрэмгийлэн эзлэх, манай улсыг хятадад хүчээр нэгтгэх их гүрний дээрэнгүй бодлого явуулж байгааг МАХН-ын баримт бичигт удаа дараа уудлан илчилсэн юм. Хятадын өнөөгийн эрх баригчид тэрхүү санаархлаа хэрэгжүүлэхэд нь Монгол-Зөвлөлтийн ган бат найрамдал, ах дүүгийн хамтын ажиллагаа саад болж байгаа тул тэд манай хоёр хоёр орны эсрэг улс төр, цэргийн талаар шууд дайсагнасан ажиллагаагаа улам хүчтэй явуулж байна. Бүрэн эрхт БНМАУ-ын дотоод хэрэгт эрээ цээргүй оролцож, манай засгийн газрын хүсэлтээр социалист Монголын энх тайван бүтээн байгуулалтыг хятадын онцгой маягийн империалистуудын довтолгооноос хамгаалах эрхэм зорилгоор манай улсын нутагт байрлаж байгаа Зөвлөлтийн цэргийн ангийг Монголоос гарахыг зүй бусаар шаардсан явдлыг Хятад, Японы гэрээний үүрэг зорилготой холбож цэгнэж үзэх ёстой юм.

4 N H Kim. "Anti-Hegemonism" and the politics of the Sino-Japanese peace treaty: a study in the Miki governments China policy.-"Asia quarterly" 1976, N 4 p 108

5 «Жэньминь жибао», 1978. 8. 14. Эне оны 10-р сард Токиод хийсэн хэвлэлийн бага хурал дээр Дэн Сяо-пин мэдэгдэхдээ хятад-японы энх тайван найрамдлын тухай гэрээний гол сүнс (утга) нь жанжлалыг эсэргүүцэхэд оршино» гэжээ. («Правда» 1978. 10. 17.

6 «Санкэй Симбун» 1975—4—3.

Нөгөө талаар японы империализмын тарьсан гай уршгийг биеэрээ амссан Монголын ард түмэн хоёр этгээдийн энх тайван, найрамдлыг хангах зорилгоосоо гажсан Хятад-Японы гэрээнээс үүсэн гарах болзошгүй хор уршгаас сэрэмжлэх нь зүйн хэрэг билээ. Тийм ч учраас БНМАУ-ын Гадаад Явдлын Яамнаас хийсэн мэдэгдэлд, «Хятадын булаан эзлэх бодлогын шууд бай нь болсон буюу цаашид болж мэдэх улс, орны төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, энх амгалан аж төрөхийн эсрэг бээжингийнхний өвөрлөж байгаа аюултай санаархлыг өөгшүүлж байна гэж тэдгээр улс үзэх үндэстэй юм»⁷ гэж тэмдэглэжээ.

Маостууд «жанжмалын эсрэг тэмцэх гэсэн лоозонгоор дэлхийн социализм, түүний бат цайз Зөвлөлтийн эсрэг харгис чиг шугамаа халхавчилж байгааг японы эрх баригчид сайн мэдэх юм. Гэтэл Японы засгийн газар Хятадын талд буулт хийж ЗХУ ба социалист бусад орны эсрэг илэрхий дайсагнасан баримт бичигт гарын үсэг зурсан байна. Япон улсын энэхүү үйл ажиллагаа нь Бээжингийнхний их гүрний дээрэнгүй дайнд түрэмгий бодлогыг зөвшөөрсөн төдийгүй, түүнийг хэрэгжүүлэхэд татагдан орж байгаа хэрэг юм. Иймд японы эрх баригчид уг гэрээ бол «Зөвлөлтийн эсрэг» биш гэж тайлбарлаж байгаа нь утгагүй зүйл юм. Аливаа гэрээ оролцогч хоёр талын санал нэгдсэний үндсэн дээр гарын үсэг зурах учиртай болохоор японы тал хятадын талтай уг асуудлаар санал нэгтэн байгаа бөгөөд хятадын өмнө гэрээгээр үүрэг хүлээсэн байх нь тодорхой байна.

Японы эрх баригчид уг гэрээ байгуулах асуудлаар нааштай чиг шугам баримталж байснаасаа гэнэт няцаж дайн түрэмгийллийн бодлого илэрхий явуулж байгаа бээжингийнхэнтэй цэргийн холбооны шинж чанар бүхий гэрээ байгуулна гэдэг бол эрүүл бус үзэгдэл бөгөөд Ази, Алс Дорнодын энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт эрс харшилж байна. Ийм учраас японы дэвшилт хүч Хятад-Японы гэрээ Япон улсад ч хор уршиг тарьж болзошгүй гэж зөвүүцэн дургүйцэж байна. «Энэхүү Япон-Хятадын гэрээний холбогдол бүхий асуудал нь манай улсын энэ оны дотоод бодлого, гадаад харилцааны хамгийн маргаантай зүйл байх төдийгүй, ганц алхам буруутвал Японы ирээдүйн түүхийг эргэлт буцалтгүй сөрөг урсгалд шидэн оруулж болзошгүй учир дайны өмнөх Япон-Германи-Итали гурвант гүрний холбооны бодит баримтыг санагдуулна» гэж профессор Наган Ёносукэ бичив.⁸

Японы эрх баригчид «жанжлах үзлийн эсрэг тэмцэх» асуудалд огт өөрөөр хандаж маогийнхантай нэг байр сууринд зогсох болсон нь санамсаргүй хэрэг бишээ. Энэ нь юуны өмнө энэ оны 5-р сард Вашингтонд, болсон ерөнхий сайд Т. Фукуда, ерөнхийлөгч Ж. Картер хоёрын уулзалттай салшгүй холбоотой юм. Уулзалтын үеэр Ж. Картер Хятадын талаар явуулж байгаа Японы бодлогыг бүхэлд нь дэмжиж байгаагаа мэдэгдээд «Энх тайван, найрамдлын тухай гэрээ» байгуулах Япон-Хятадын хэлэлцээ амжилттай болно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн байна.⁹

«Жанжлалын эсрэг тэмцэх» тухай заалтыг хэрхэн тайлбарлах асуудлаас болж мухардалд ороод гурван жил гаруй болсон хэлэлцээг японы тал дээрх уулзалтын дараа яаравчлан сэргээж улмаар гэрээнд гарын үсэг зурсан явдал Хятад-Японы улс төрийн харилцаа Япон-Америкийн харилцааны стратегитай уялдах болсонтой шууд холбоотой юм. Хятад, Японы эрх баригчдын сүүлийн үеийн хийсэн мэдэгдлүүд үүнийг гэрчилж байна.

7 «Үнэн» сонин, 1978 оны 8-р сарын 31

8 «Тюо корон» сэтгүүл, 1978 он, № 5.

9 "Business Japan" 1978, № 8.

Жишээ нь: Хятадын удирдагчид, түүний дотор Дэн Сяо-пин Японы янз бүрийн төлөөлөгчидтэй уулзахдаа Япон, Хятад хоёр гар гараасаа барилцан, Япон, Хятад, АНУ нэгдэж ЗХУ-ыг бүслэх ёстой¹⁰ гэж нэг бус удаа мэдэгдэж байжээ. Японы Гадаад Явдлын яамны сайд С. Сонода 1978 оны 1-р сарын 26-нд Либерал-ардчилсан намын улс төрийн зохицуулах комиссын хурал дээр «Япон-Хятадын энх тайвны гэрээг японы биеэ даасан ажиллагаа гэж хэлсэнд орвол АНУ-ын дэлхий дахины стратегийн нэг хэсэг гэж хэлж болно.¹¹ гэж хэлжээ. Уг чанартаа Дэн Сяо-пин, Сонода хоёр агуулгын хувьд адилхан, зорилгын хувьд нэг зүйлийг ярьж байна. Энэхүү осолтой хуйвалдаанаар Хятад өөрийн талаас «жанжлалын эсрэг» гэгч буюу Зөвлөлтийн эсрэг «өргөн фронт» байгуулах эрмэлзлэлээ хэрэгжүүлэх замд нэгэнт шилжих анхны алхамд Хятад-Японы «Энх тайван, найрамдлын тухай гэрээний» халхавчийн дор Япон улсыг өөрийн их гүрний жанжлах бодлогын хүрээнд татан оруулж амжсаныг харууллаа.

АНУ-ын эрх баригчид Хятад-Японы гэрээг сайшаах болсон нь тохиолдлын чанартай зүйл хэрхэвч бишээ. Хятад-Японы хооронд хэвийн харилцаа сэргэхээс өмнө Хятадын удирдлага, Бээжингийн суртал нэвтрүүлэг бараг өдөр болгон Япон-Америкийн «Аюулгүйн гэрээг» буруу шааж түүний аюул заналын тухай ярьдаг байлаа. 1972 оны 9-р сараас хойш Хятадын эрх баригчид уг гэрээг буруушаахаа больсон төдийгүй, түүнийг дэмждэг болсон юм. Одоо маогийнхан Хятад-Японы гэрээгээр дамжуулан Бээжин-Токио-Вашингтон гэсэн гурвын холбоо бий болгохыг оролдож байгаа нь Япон, Америкийн харгис хүчний бөөн олз болж байна.

Хятад Японы харилцаанд гадаад худалдааны гүйцэтгэж байгаа үүрэг. Хятадын эдийн засгийн гадаад харилцаа нь бээжингийн эрх баригчдын гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагааны чухал хэсэг юм. Хятадын , удирдагчдын гадаад эдийн засгийн бодлогод улс төрийн үзэл бодол нь урьтал болж байдаг билээ. 1950-иад оны сүүлчээс маогийн бүлэг марксч ленинч үзэл санаанаас ухарч түүний гадаад, дотоод бодлого үндсэрхэг байр сууринд илэрхий шилжиж, эдийн засгийн гадаад харилцаанд өөрчлөлт гарсан юм. Мао Цзэдун гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар барууны орнуудыг түших бодлого баримтлан, практик үйл ажиллагааны хувьд социалист улсуудтай хамтын ажиллагаагаа багасгаж, капиталист орнуудад ойртох чиг шугамыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

БНХАУ байгуулагдсанаас хойшхи эхний 10 жилд тус улсын улс ардын аж ахуйн салбарууд үндсэндээ жигд хөгжиж байсан бол түүнээс хойш Бээжингийн эрх баригчид цэрэг дайны зориулалттай салбаруудыг голчлон хөгжүүлэх болсон байна. Энэ нь Хятадын улс ардын аж ахуйн хөгжилтөнд олон талаар нөлөөлж, ард түмний аж байдлыг сайжруулахад үлэмж саад учруулсаар байна.

ЗХУ ба социалист бусад оронтой худалдаа-эдийн засгийн өргөн харилцаатай байсан үед БНХАУ байгаа зүйлээ өгч, жинхэнэ хэрэгтэй зүйлээ авдаг байсан бол одоо капиталист орнуудын зөвхөн сонирхож байгаа зүйлийг экспортлодог болсноос хятадын гадаад худалдаа ямагт хүнд байдалд байна. Хятадын эрх баригчид БНХАУ-ын гадаад худалдааны хувь заяаг ийнхүү буруу тийш нь залсан болохоор 1974 оны капиталист ертөнцийн эдийн засгийн хямрал Хятад орныг дайрч өнгөрсөн юм. Жишээ нь: капитализмын эдийн засгийн уналт (1974 он) нь Хятад улс экспортынхоо хэмжээг хорогдуулахад хүргэсэн байна. Гэвч тус орны дотоод хэрэгцээнээс болж Хятад улс тоног төхөөрөмж, хүнсний хэрэгцээний бүр

10 «Майнити симбун» 1978 оны 4-р сарын 2.

11 «Тью корон» 1978 оны № 5, 77-р тал

тарианы зүйлийн импортыг нэмэгдүүлэх шаардлагатай болж, тэр тусмаа 1913 оноос өндөр үнээр авахад хүрсэн юм. Импортын барааг өндөр үнээр авч, экспортын бараагаа олон улсын зах зээлийн үнээс доогуур үнээр гаргаснаас болж зөвхөн 1914 онд 240 сая долларын хохиролд учирсан байна. «өөрийн хүчинд тулгуурлан хөгжих» гэсэн лоозонгоор халхавч хийж, Мао Цзэдун БНХАУ-ыг социалист системээс хөндийрүүлэн, капиталист ертөнцийг түших замд оруулсны гайг үүнээс харж болох юм. Хятадын удирдагчдын үндсэрхэг үзлийн үүднээс урган гарч байгаа эдийн засгийн гадаад бодлого нь монополист хөрөнгөтнүүдэд, түүний дотор японы үйлдвэр худалдааны эздэд тун ч таалагдаж байгаа юм. Тийм учраас Хятад Японы гадаад худалдаа түргэн хөгжиж Япон нь Хятадын гадаад худалдааны гол түнш болжээ. 1976 онд Хятад-Японы гадаад худалдааны нийт хэмжээ 3 миллиард гаруй долларт хүрчээ. 1974, 1975 онуудад үүнээс ч илүү хэмжээнд хүрсэн юм. Ийнхүү Япон-Хятадын гадаад худалдааны жилийн нийт хэмжээ нь дипломат харилцаагүй байсан 1966 он буюу 10 жилийн өмнөх 620 сая доллар байсныг бодвол даруй 5 дахин нэмэгджээ. 1977 оны эхний 9 сард тус хоёр орны худалдааны нийт хэмжээ 2,461710000 сая доллар болсон нь 1976 оны мөн үеийнхээс 6% өссөн байна.¹² Дээр хугацаанд хятадын экспорт 1064960000 долларт хүрч 13,6% өссөн ба импортын хэмжээ нь 1396750000 доллар болж 09% өсчээ. Япон улс Хятадаас авч байгаа бараанд түүхий нефть нилээд чухал байр эзэлж байна. Гэтэл 1976 онд Хятадаас авсан түүхий нефтийн хэмжээ 1975 оны хоос 2 сая тонноор буурч 1 сая орчим тонн болсон байна. Энэ нь Хятадын нефтийн үнэ өндөр байгаа ба нөгөө талаар нефть химийн үйлдвэрүүд байгуулж дотоод хэрэгцээ нь нэмэгдсэнтэй холбоотой юм. Гэтэл Япон нь Жилдээ 170 сая тонн нефть зарцуулж байгаа ба одоогийн байдлаар 15 хоногийн нөөцтэй болж, 1980 он гэхэд 90 хоногийн нөөцтэй болох зорилт тавьж байгаа ажээ. Иймд хятадаас түүхий нефть авах нь японд олон талын ашигтай. Энэ учраас удаан хугацааны контрактын үндсэн дээр 1981 онд хятадаас 15 сая тонн ба түүнээс илүү хэмжээний нефть авах тухай тохиролцсон байна.

Хятадын ган үйлдвэрлэлт 1914 онд 23,8 сая тонн байсан бол 1976 онд 21 сая тонн болтол буурсан байна. Энэ нь 1971 оны хэмжээ юм.¹³ Хятадын ган гаргалт тогтворгүйн дээр чанар нь орчин үеийн хэмжээнд хүрэх болоогүй байгаа тул японоос худалдан авах гангийн хэмжээ нилээд нэмэгдэхээр барахгүй гангийн үйлдвэр бариулах хэлэлцээтэй ажээ. Японоос авах гангийн хэмжээ ийнхүү нэмэгдэж байгаа нь Хятад улс цэргийн үйлдвэрлэлийг хөгжүүлж байгаатай шууд холбоотой юм.

Фукудагийн засгийн газар Хятадтай «Энх тайван, найрамдлын тухай гэрээ» байгуулахад ихэд яарсаны учир бол засгийн эрхэнд цаашид үлдэх гэсэн Либерал-ардчилсан намын эрх баригчдын тактикаас гадна Японы худалдаа-аж үйлдвэрийн капиталын гадаад зах зээлийн хүрээг хятадаар тэлж өргөтгөх гэсэн улс төр, эдийн засгийн сонирхол юм. Японы эдийн засгийн байгууллагуудын холбоо (Кэйданрэн)-ны дарга Тосио Доко тэргүүтэй худалдааны төлөөлөгчид 1971 оны 4-р сарын эхээр Бээжинд очиж Хятад-Японы хооронд худалдааны урт хугацаатай хэлэлцээр байгуулахаар хятадынхантай хэлэлцэн тохирсон юм. Энэ үндсэн дээр 1978 оны 2-р сарын 16-нд Хятад-Японы удаан хугацаатай хэлэлцээрт Бээжин хотноо гарын үсэг зурсан байна. 8 жилийн хугацаатай (1978—1986) энэ хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацаанд хоёр талын тус бүрийн экспортын хэм

12 "Business Japan" Nol. 1978

13 «Майнити дейли ньюс» 1977 оны 2-р сарын 22.

жээ нь 10 миллиард доллар болох ажээ. 10 жилийн хугацаатай байгуулсан Хятад-Японы «Энх тайван, найрамдлын» тухай гэрээ нь дээр дурдсан 3 жилийн хугацаатай Хятад-Японы эдийн засгийн хэлэлцээрийн биелэлтэнд улс төрийн баталгаа болж өгөх юм.

Хятад-Японы цэргийн харилцаа. Хятад-Япон хоёр зөвхөн улс төр, эдийн засгийн талаар хамтран ажиллаж байгаа төдийгүй, бас цэргийн талаар хамтран ажиллаж эхлэв. Энэ оны 9-р сарын эхээр Хятадын ардын чөлөөлөх армийн жанжин штабын орлогч дарга Чжан Цай-цян тэргүүтэй хятадын цэргийн төлөөлөгчид Японд очиж, Японы жанжин штабын дарга Та нарын нэгдсэн зөвлөлийн дарга Т. Такасина болон Японы үндэсний Катлан хамгаалах газрын төлөөлөгчидтэй уулзаж, Японы армийн бааз, объектуудын байдалтай танилцаж цэргийн үйлдвэрүүдийг үзжээ.

Бээжингийн цэргийн төлөөлөгчдийн гол зорилго бол японы цэргийн хэнтэй өргөн холбоо тогтоож, цэргийн аж үйлдвэрийн эздээс орчин үеийн зэвсэг, цэргийн техник, технологи авч байх явдал юм гэж японы хэвлэлүүдэд бичиж байна. Хятад-Японы «Энх тайван, найрамдлын тухай гэрээ» гэгчид гарын үсэг зурсны дараахан өндөр хэмжээний цэргийн төлөөлөгчид дээрх зорилгоор Японд айлчилсан нь уг гэрээ «Ази ба Номхон далайн районы энх тайван, аюулгүй байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой» гэж хятадын суртах нэвтрүүлгийн хэлж байгаа огт хуурамч зүйл болохыг бүр ч тодорхой нотолж байна.

Хэвлэлийн мэдээнээс үзвэл, Японы «өөрийгөө хамгаалах хүчний» тэнгисийн цэргийн штабын дарга байсан Х. Нагасова тэргүүтэй цэргийн ахмад зүтгэлтнүүд энэ оны эхний хагаст Хятадад айлчилсан байна.

БХАТХ-ын Байнгын хорооны орлогч дарга Тань Чжень-линь Х. Нагасоватай ярилцахдаа Япон улс үлэмж тооны цэрэг, их буу, танк, хөлөг онгол, пуужин болон бусад зэр зэвсэгтэй болох нь зүйтэй гэж түүнд хэлжээ.

Бээжингийн эрх баригчид японы Тэргийнхэнтэй 1977 онд ч нэг бус удаа уулзаж байв.

Бээжингийн шинэ удирдагчид японы шинэ хуучин цэргийн эрхтнийг Хятад нутагт ийнхүү дахин хөл гишгүүлж, тэр тусмаа урьж уулзаж байгаа нь туйлын гутамшигтай хэрэг юм. Учир нь үндэснийхээ тусгаар тогтнолын төлөө, хагас колонийн гав гинжнээс ангижрахын төлөө хятадын ард түмэн олон жилийн турш амь өрсөн байлдаж байсан заналт дайсан агсан японы империалистуудтай хятадын удирдагчид хэлхээ холбоо тогтооно гэдэг бол японы милитарист бүлэгтэй сүлбэлдэж, тэднийг өөрсдийн их гүрний дээрэнгүй, жанжлах санаархлаа хэрэгжүүлэхэд ашиглах гэсэн бодлого юм. Энэ бол хятад, японы ард түмний аль алины нь эрх ашигт харшилж байна. Яагаад гэвэл японы одоогийн даган мөрдөж байгаа үндсэн хуулийн 9-р зүйлд зааснаар япон нь зэвсэгт хүчингүй улс байх ёстой юм. Гэтэл Япон улс зэвсэгт хүчинтэй болсон төдийгүй, японы харгис хүчин үндсэн хуулийн дээрх заалтыг өөрчлөхийг элдвээр оролдож байна. Энэ нь японд милитаризм сэргэж байгааг цагаатгах гэсэн оролдлого юм. Хятад-Японы хооронд хэвийн харилцаа тогтохоос өмнө Японд милитаризм сэргэж байгаа ба түүний аюул заналын тухай хятадын эрх баригчид олонтоо ярьж байв. Түүний сүүлчийн нэг баримтыг хэлэхэд Чжоу Эньлай 1970 оны 12-р сарын 8-нд японы тариачны хөдөлгөөний зүтгэлтнүүдийн төлөөлөгчидтэй уулзаж японд милитаризм сэргэж байгаа эсэх тухай ярихдаа «Милитаризм сэргэх үү? үгүй юү гэдгийг тогтоохдоо түүний бодлогыг харах хэрэгтэй, милитаризм сэргэж байгаа эсэхийг түүний бодлого тодорхойлж өгнө.

10 жилийн өмнө Япон нь АНУ-тай аюулгүйн гэрээ шинэчлэн байгуулж, өнгөрсөн оны 11-р сард Сато (тэр үеийн Японы ерөнхий сайд Д. Х) Никсонтой дахин хэлэлцээ хийсэн, мөн японы зэвсэгт хүчнийг өргөтгөх 4-р төлөвлөгөө зэргээс бүх юм тодорхой байна. Япон нь америкийн империализмыг түшиглэн милитаризмыг хүчтэй болгон гадаадад түрэмгийлэл үйлдэх гэж байна. Иймд тэд Солонгосын хойг ба Тайванийг Японы аюулгүй шугам гэж тогтоосон байна¹⁴ гэжээ. Мөн Хятадын хэвлэлд ч Японд Милитаризм сэргэж байгааг олонтоо бичдэг байв. 1967—1970 онд «Жэнминь жибао» сонин Японд милитаризм сэргэж байгааг 551 удаа зэмлэн буруушааж байжээ.

Энэ бүхнээс үзэхэд Хятадын эрх баригчид Японд милитаризм сэргэж байгаад ихэд сэтгэл түгшиж байсан мэт боловч Чжоу Энълай Японд милитаризм сэргэж байгаа ба мөн түүний баримт болгон жишээнд авсан японы зэвсэгт хүчнийг өргөтгөх IV төлөвлөгөөг зэмлэн буруушааж байсан байр сууринаасаа төдөлгүй бүрмөсөн няцжээ. Тэр ч байтугай Чжоу Энълай 1972 оны 9-р сард Японы ерөнхий сайд, Какуэй Танакатай уулзах үед Япон улс зэвсэгт хүчээ зузаатгахыг зөвлөж «хэрэв Япон руу ЗХУ довтолбол Хятад улс Японд цэргийн тусламж үзүүлэх болно гэж мэдэгдсэн байна. Иймд Бээжингийн удирдагчид Японы харгис хүчин, түүний дотор цэргийнхний төлөөлөгчидтэй шууд харилцаа тогтоож байгаа нь Японтой цэргийн холбоо тогтоох зорилготой болох нь тодорхой байна. Мөн Японы зэвсэгт хүчийг өргөтгөх IV төлөвлөгөө нь цэргийн сүр хүчийг бэхжүүлэх талаар хийж байгаа зөв зүйтэй алхам гэж Хятад улс баяр хүргэж байна гэж Чжоу Энълай япон түншдээ хэлсэн байна.¹⁵ Тэгвэл Чжоу Энълайн зэмлэж байсан ба баяр хүргэж байсан японы зэвсэгт хүчнийг өргөтгөх IV төлөвлөгөө (1970—1976) ба түүний өмнөх арга хэмжээнүүдийг авч үзье. 1958 оноос хойш Япон нь «Өерийгөө хамгаалах хүчнийг» төлөвлөгөөтэй хөгжүүлж, энэ хугацаанд 3 удаагийн 5 жилийн программыг хэрэгжүүлсэн байна. Тэдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Японы засгийн газар үлэмжхэн хэмжээний мөнгө зарцуулсан байна. Милитализм бол монополит хөрөнгөтөн ангийн дарангуйллын хэрэгсэл учраас империалист гүрнүүд дотоодын дэвшилт хөдөлгөөнийг дарах, гадаад түрэмгийлэлд бэлтгэхдээ цэргийн зардлыг хэмжээ хязгааргүй нэмж, улс орныхоо эдийн засгийг цэрэг дайны байдалд зохицуулж хөгжүүлдэг билээ. Жишээ нь: 1958-1976 онуудад японы цэргийн зардал нийтдээ 10 гаруй триллион иен болжээ. Тэгвэл ойрын таван жилд (1977-1981) цэргийн зардалд 12 триллион иен зарцуулахаар японы засгийн газар шийдсэн байна.

Японы харгис хүчин тус оронд ердийн зэвсэг эзэмшсэн арми байгуулсан явдлыг элдвээр цагаатгаж байгаа төдийгүй, цөмийн зэвсэг эзэмших явдлыг зөвтгөж байна. Гадаадын хэвлэл АНУ-ын тагнуулын төв газрын нууц баримт мэдээг түшиглэн Япон улс 1980 он гэхэд цөмийн зэвсэгтэй болох тухай бичсэн байна.¹⁶ Японы Сайд нарын танхимын хууль цаазны товчооны дарга Такануджи 1966 оны 12-р сарын 3-нд Японы парламентын дээд танхимын «Япон-өмнөт Солонгосын гэрээний» тусгай комиссын хурал дээр гарсан асуултанд хариулахдаа Япон «цөмийн зэвсэгтэй байх нь үндсэн хуулинд харшлахгүй» гэж хариулсан байна.¹⁷ Мөн хурал дээр тэр үеийн ерөнхий сайд Э. Сато «Такацуджигийн хариултыг залруулах шаардлагагүй» гэж мэдэгдээд, «үүнийг засгийн газрын байр суурь гэж

14 «Цзу Го», 1971 оны 11-р сард. № 92.

15 «Нью-Йорк таймс» 1972 оны 12-р сарын 14

16 «Синдао жибао», 1978 оны 3-р сарын 23.

17 «Жэньминь жибао» сонин 1966 оны 12-р сарын 6.

үзэж болно»¹⁸ гэж тайлбарлав. Япон нь нилээд эртнээс цөмийн зэвсэг эзэмших зорилтыг тавьсан байна. Жишээ нь ерөнхий сайд байсан Киси аль 1957 оны 5-р сарын 7-нд «Хэрэв цөмийн зэвсэг нь батлан хамгаалах чанартай байвал түүнийг эзэмшиж болохгүй гэх газаргүй»¹⁹ гэж хэлж байв. Кисийн энэ санааг Японы одоогийн Ерөнхий сайд Фукуда энэ оны 3-р сарын 11-нд Парламентад хэлсэн үгэндээ давтсан байна.

АНУ-ын цөмийн мэргэжилтэн Себалд, Спинкс нарын тооцоолсноор бол 1975 он гэхэд Япон нь тус бүр нь Нагасакид хаясан атомын бөмбөгтэй тэнцэх 600 атомын бөмбөг үйлдвэрлэх плутонитой болж чадах ажээ. IV төлөвлөгөө хэрэгжсэнээр Японы армийн эзэмших галын хүч нь дэлхийн II дайны үед тус улсын армийн эзэмшиж байсан галын хүчээс 30 дахин нэмэгдэх юм.²⁰ Японы үндэсний батлан хамгаалах газрын үзэж байгаагаар бол дээрх төлөвлөгөө биелснээр Япон «Идэвхгүй батлан хамгаалалтанд» шилжих ажээ.²¹ Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар уг төлөвлөгөө хэрэгжсэний эцэст Японы арми нь үндсэн бүх үзүүлэлтээр хөрөнгөтөн ертөнцөд 7-р байрыг эзэлж байна. Цэргийн зардал нэмэгдэж байгаа хэмжээний хувьд Япон нь хөрөнгөтөн ертөнцөд нэгдүгээр байранд явж байна.

1976 оны 3-р сарын байдлаар японы хуурай замын цэрэг 154 мянган хүн байснаас 56 мянга нь жагсаалын цэрэг, 98 мянга нь бага дунд, ахлах дарга ба генералууд байв. Командын бүрэлдэхүүний хувьд ийнхүү их байгаа нь армийг дуртай цагтаа өргөтгөх боломжтой юм.

Японы нисэх хүчин төлөвлөгөөг зохиож байсан үеийг бодвол нилээд хүчирхэгжив. 1976 оны 3-р сард бүгд 45 мянган хүнтэй байсан ба одоо японы нисэх хүчин «Ф- ЧЭЖ», «Ф-104Ж», «Ф—86»²² зэрэг орчин үеийн сөнөөгч онгоц байгаагаас гадна 1977 оны 12-р сарын сүүлчээр АНУ-аас сөнөөгч бөмбөгдөгч «Ф—15» 100, далайд шумбагч онгоц эсэргүүцэх нисэх онгоц «П-3С» 45-ыг тус тус худалдан авахаар Японы үндэсний батлан хамгаалах зөвлөл шийдвэрлэсэн байна. Тэдгээр нисэх онгоцыг вахад 1,1 триллион иен буюу 4,5 миллиард доллар зарцуулах юм.²³

Далайн флотын хүчин чадлын хувьд ганц жишээ хэлэхэд одоо Япон улсад далайн шумбагч онгоц эсэргүүцэх нисэх онгоц 132 байгаа нь дэлхий дээр гуравдугаар байр эзэлж байна. Японы зэвсэгт хүчин түргэн хурдацтай бүх талаар хөгжиж байгаа нь 1960 онд шинэчилж байгуулсан Япон-Америкийн «Аюулгүй гэрээтэй» шууд холбоотой юм. Энэ гэрээгээр АНУ японы армийг өөрийн Алс Дорнод дахь шуурхай отряд болгох зорилго тавьсан байна. Жишээ нь Карибын тэнгисийн хямралын үед Японы «өөрийгөө хамгаалах хүчний» агаарын хүчин мөн бусад зарим анги тэр байдалд зохицсон байдалд шуурхай орсон байна.

Одоо энэ гэрээний ажил төрлийн аппарат болох зохицуулах комиссыг байгуулсан ба энэ комисс нь онц байдлын үед Япон-Америкийн цэргийн хамтын ажиллагааг зохицуулах үүрэгтэй.

АНУ нисэх онгоц болон байлдааны бусад хэрэгслийг Японд нийлүүлж байгаа нь зэвсэг худалдаж байгаа зүгээр нэг үзэгдэл биш, харин хэрэгцээ тохиолдвол Алс Дорнодод Япон үүрэг гүйцэтгэх учиртай тул түүнийг ийнхүү зэвсэглэж байна. Өөрөөр хэлбэл Японы арми АНУ-ын Номхон далай дахь зэвсэгт хүчний нэгэн жигүүр болж байна.

18 «Асахи симбун», 1966 оны 12-р сарын 4.

19 Мөн тэнд.

20 «Фар истрен экономики ревью» 1972 он.

21 Мөн тэнд

22 Дзизэтай нанкан, Токио, 1976, 528-р тал.

23 «Правда» сонин, 1977 оны 12-р сарын 30.

Энэ бүхнээс үзэхэд Япон-Америкийн «аюулгүйн гэрээ» нь Ази ба Алс Дорнодод аюул занал учруулж байгаа цэргийн холбоо юм.

Японы үйлдвэр-худалдааны эзэд, цэргийнхэн японы зэвсэгт хүчний хүчин чадлыг улам нэмэгдүүлэхийг японы засгийн газарт шаардаж байна. ХКН-ын Төв хэвлэл «Акахата» сонинд нийтэлсэн материалаас үзвэл Японы харгис хүчин зөвхөн зэвсэглэлийн хойноос хөөцөлдөөд зогсохгүй, улс төр, эдийн засаг болон нийгмийн амьдралын бусад салбарыг милитаристчилах шаардлагыг илэрхий тавьж байна. Өөрөөр хэлбэл дайны өмнөх цэрэг-фашистын дэглэмийг дахин тогтоохыг шаардаж байгаа юм. Энэ бол осолтой хэрэг. Учир нь дэлхийн II дайны үед японы империалистууд Азийн улсуудад түрэмгийлэл үйлдсэний улмаас 20 орчим сая энгийн номхон хүн ард хэлмэгджээ. Япон хүн ч 3 сая гаруй алагджээ.

Хятадын өнөөгийн эрх баригчид Японы зэвсэгт хүчнийг улам хүчтэй болгохыг уриалж буй нь хэрэг дээрээ японд милитаризм сэргэж байгааг сайшааж байна гэсэн үг юм. Нөгөө талаас Хятад ХКН-ын XI их хурал, 1918 оны хавар хуралдсан БХАТХ-ын чуулганы шийдвэрийн дагуу армия шинэтгэх зорилгод японоос юуны өмнө зэвсэг техник, мэргэжилтнийг нь ашиглах, улмаар милитарист бүлэгтэй нь хуйвалдах замаар японыг Зөвлөлтийн эсрэг «өргөн фронт»-доо татан элсүүлж ЗХУ-тай мөргөлдүүлж орхиод Ази, Номхон далайн районд ганцаараа жанжлах гэсэн чиг шугам баримталж байна. Энэ чиглэлээр хийгдэж буй дипломат алхамын түрүүч нь Хятад-Японы «Энх тайван, найрамдлын тухай гэрээнд» хятадын тал хүчлэн оруулсан «жанжлалын эсрэг» тэмцэх тухай зүйл боллоо.

Японы зэвсэгт хүчин өргөжиж, түүний зэвсэглэл улам шинэчлэгдэж байгаагийн зэрэгцээ удирдах аппаратын эрх үүргийг өргөтгөж байна. Японы үндэсний батлан хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнд урьд ерөнхий сайд, Сангийн яамны сайд, Гадаад явдлын яамны сайд, Үндэсний батлан хамгаалах газрын дарга ордог байсан бол 1912 оноос энэ зөвлөлийн бүрэлдэхүүнд Гадаад худалдаа ба үйлдвэрийн яамны сайд, Шинжлэх ухаан техникийн газрын дарга, Сайд нарын танхимын ерөнхий нарийн бчгийн дарга, Нийгмийг аюулаас хамгаалах комиссын дарга зэрэг хүмүүсийг нэмэн оруулжээ.

Японд милитаризм шатлан сэргэж байгааг дээрх бүх баримт нотолж байна.

Японы милитаризм ийнхүү толгойгоо дахин өндийлгөж, нөгөөтэйгүүр Бээжингийн удирдлага дайны хэнээрхлийг дэвэргэж, дайнд улайран бэлтгэж байгаа өнөө үед Хятад, Япон хоёр цэргийн хэлхээ холбоо тогтоон, арьсны үзэл дээр нэгдэж байгаа нь Ази болон даян дэлхийн улс түмний энх тайван, аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүйг хайхрахгүй байж болохгүй.

Д. Хурэлтого

КИТАЙСКО-ЯПОНСКИЕ ОТНОШЕНИЯ ЗА ПОСЛЕДНЕЕ ВРЕМЯ

Резюме

Статья посвящена анализу хода развития китайско-японских отношений за последнее время.

Мир и безопасность в Азии в определенной степени зависят от того, как будут развиваться отношения между двумя азиатскими государствами-

ми-Китаем и Японией, и на каких принципах будут основываться их отношения. Однако, анализ развития китайско-японских отношений за последние годы показывает, что эти отношения представляют большую угрозу миру и безопасности в Азии. Об этом ярче всего свидетельствует недавнее подписание китайско-японского договора «о мире и дружбе».

Вопреки уверениям пекинских лидеров и правящих кругов Японии, этот договор имеет ярко выраженный характер военного союза, заключенного между маоистами и милитаристскими кругами Японии и направленного своим острием против мира и безопасности на родине Азии и всего Мира.

Включение в договор статьи о совместном выступлении против «гегемонии» продиктовано далекойдущей воинственной стратегией маоистов и японских реакционных сил против мирового социализма и мира во всем мире, и прежде всего, против Советского Союза-оплота мира и социализма на земле. Что касается цели пенкинских лидеров, то они стремятся посредством китайско-японского договора создать тройственный союз «Пекин-Токио-Вашингтон» в борьбе против Советского Союза, других социалистических стран и всех прогрессивных, демократических сил мира. В этом плане политика Пекина не только совпадает с интересами реакционных кругов США, но и непосредственно действует в угоду империалистическим силам в целом. Однако, подобные планы противников мира всех мастей обречены на провал.

Китай и Япония развивают свои отношения не только в политической и экономической области, но и в военной. Сразу после подписания договора «о мире и дружбе», в Японию прибыла военная делегация Китая во главе с заместителем начальника Генерального штаба НОАК Чжан Цай-Инь с целью установить деловые контакты с военными кругами Японии, в чем немало заинтересованы и представители милитаристской группы Японии.

В заключение автор отмечает, что в основе китайско-японского сближения лежат, в конечном итоге, расизм и шовинизм, тесно переплетающиеся с милитаризацией Китая и возрождением милитаризма в Японии. Исходя из этой обстановки, нельзя недооценивать угрозу дальнейшего расширения сотрудничества между Китаем и Японией, которое влечет за собой опасные последствия для дела мира и безопасности народов Азии и всего прогрессивного человечества.